Умайн хүзүүний үрэвсэлтэй эмэгтэйчүүдийн үтрээний наацын шинжилгээг судалсан дүн

Г.Есөн-Эрдэнэ[1], О.Баатархүү[2], Б.Болорчимэг[1]

[1]АШУҮИС, АУС, Эх барих, эмэгтэйчүүд судлалын тэнхим
[2]АШУҮИС, АУС, Халдварт өвчин судлалын тэмхим
Цахим шуудан: yesuunuu0608@gmail.com, Утас: 88859694

Түлхүүр үг:

Бэлгийн замаар дамжих халдвар
Умайн хүзүү
Нюжент оноо
Полемераза гинжин урвал
Үтрээний үрэвсэл

Товч утга:

Үндэслэл: Умайн хүзүүний үрэвсэл нь умайн хүзүүний дотор сувгаас харагдахуйц эсвэл умайн хүзүүний түрхэцийн шинжилгээгээр илэрдэг идээт болон салст-идээт ялгадасаар тодорхойлогддог эмнэл зүйн хам шинж юм.[1-3] Умайн хүзүүний цочмог үрэвсэл нь гэмтэл буюу төрөлт, үр хөндөлтийн үед үүссэн умайн хүзүүний урагдлаас үүдэлтэй байж болох ч ихэвчлэн халдварт өвчин үүсгэгч, ялангуяа Нейссерийн гонококк, Хламид, Энгийн герпес вирус үүсгэдэг.[2] **Зорилго:** Жирэмсэн бус умайн хүзүүний үрэвсэлтэй эмэгтэйчүүдийн үүсгэгчидийг илүүлэх ба лабораторийн шинжилгээг уяалдуулан судлаж үр дүнг хянах. **Арга, аргачлал:** Бид энэ судлагааг хийж гүйцэтгэхдээ улаанбаатар хотын 18-аас 49 хүртэл насны нийт 100 эмэгтэйг хамруулсан бөгөөд ингэхдээ дүүргийн эрүүл мэндийн төвүүдээр үйлчлүүлсэн эмэгтэйчүүдээс санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн умайн дотуур үзлэгээр умайн хүзүүний үрэвсэлтэй болох нь батлагдсан эмэгтэйчүүдийг судалгаанд хамруулсан. **Үр дүн:** Умайн хүзүүний үрэвсэлтэй эмэгтэйчүүдийн 81% (81) өвөрмөц үүсгэгчээр үүсгэгдсэн байгаагаас 68.9% (62) нь Гарднеррелла вагиналис, 43.3% (39) нь Уреаплазм парвум, 36.6% (33) нь Микоплазм хоминис, 32.2% (29) Кандида албинкас, 20% (18) нь Цитомегаловирус, 17.7% (16) нь Уреаплазм уреалитикум, 8.8% (8) нь Хламид, 8.9% (8) нь Трихомониаз, 4.4% (4) нь Нейссерийн гонококкын халдвар байна. Судалгаанд хамрагдасадын 86.4% (70) умайн хүзүүний хавсарсан халдвартай. Давтан шинжилгээгээр Микоплазм гениталиум халдвар 50%, Хламид болон Трихомониазын халдвар 100% эдгэрсэн байна. Үтрээний наалдацын шинжилгээгээр тодорхойлоход 43.2% (35) ньюжент шалгуураар 0-3 оноотой, 51.8% (42) 4-6 оноотой, 4.9% (4) 7-10 оноотой байгаа нь умайн хүзүүний үрэвсэлтэй эмэгтэйчүүдийн дийлэнх нь үтрээний үрэвсэлтэй байна. **Дүгнэлт:** Полимераза гинжин урвалын оношлууураар өвөрмөц үүсгэгчидыг тодорхойлон умайн хүзүүний үрэвсэлтэй эмэгтэйчүүдэд үтрээний наацын шинжилгээгээр Лактобацилл, Грам эерэг болон сөрөг эмгэг төрөгч нян, Мобилункусуудыг микроскопоор харж үнэлэхэд (Ньюжентийн шалгуур) нянгийн гаралтай үртээний үрэвсэл буюу 7-10 оноотой 4.9%(4) тодорхойлгдсон нь умайн хүзүүний үрэвсэл үүсч байгаа хамаарал сул байна.

Үндэслэл: Умайн хүзүүний үрэвсэл нь умайн хүзүүний дотор сувгаас харагдахуйц эсвэл умайн хүзүүний түрхэцийн шинжилгээгээр илэрдэг идээт болон салст-идээт ялгадасаар тодорхойлогддог эмнэл зүйн хам шинж юм.[1-3] Умайн хүзүүний цочмог үрэвсэл нь гэмтэл буюу төрөлт, үр хөндөлтийн үед үүссэн умайн хүзүүний урагдлаас үүдэлтэй байж болох ч ихэвчлэн бэлгийн замаар дамжих халдварт өвчин үүсгэгч, ялангуяа нейссерийн гонококк, хламид, энгийн герпес вирус үүсгэдэг.[2] Умайн хүзүү улайж, үрэвсэлтэй удаан явснаас умайн хүзүүний шарх үүсдэг ба шарх нь хорт хавдрын урьдал өвчин болдог.[4]

Монгол улсын статистикын мэдээллийн нэгдсэн сангаас 2019 онд улсын нийт хүн амын

хэмжээнд 3296866 хүн байгаагаас 50.8% (1677293)-ийг эмэгтэйчүүд үүнээс 51,6% (865781) нь нөхөн үржихүйн насны (15-49нас) эмэгтэйчүүд байна. Дэлхийн олон улсын байгууллагын хийсэн судалгаагаар эмэгтэйчүүдийн эмнэлэгт үзүүлж буй эмэгтэйчүүдийн 70% орчим нь бага аарцгийн эрхтний үрэвсэлт өвчинтэй байгаагаас үртээний үрэвсэл, умайн хүзүүний үрэвсэл нь зонхилж байна. Мөн манай оронд эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчний ангилал түүний тоо баримтыг судлан эмчилгээний үр дүнг боловсруулсан статистикийн тоо баримт хомс байна.

Зорилго: Жирэмсэн бус умайн хүзүүний үрэвсэлтэй эмэгтэйчүүдийн үүсгэгчидийг илүүлэх ба лабораторийн шинжилгээг уялдуулан судлаж үр дүнг хянах.

Арга, аргачлал: Бид энэ судлагааг хийж гүйцэтгэхдээ улаанбаатар хотын 18-аас 49 хүртэл насны нийт 100 эмэгтэйг хамруулсан бөгөөд ингэхдээ дүүргийн эрүүл мэндийн төвүүдээр үйлчлүүлсэн эмэгтэйчүүдээс санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн умайн дотуур үзлэгээрумайнхүзүүнийүрэвсэлтэйболохньбатлагдсан эмэгтэйчүүдийг судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдасад умайн хүзүүнээс авсан арчидасаас тусгай тэжээлт орчинд 30-40 удаа дүрж 2°C-8°C хэмд байлгаж нийт 14 үүсгэгчидийг илрүүлэх молекул биологийн шинжилгээгээр GeneFlow STD Array Test Kit-Hybridization Kit оношлууpаар тодорхойллоо. Үтрээний наацын шинжилгээний үр дүнг Лактобацилл (үтрээний хэвийн бичил биет) цөөрсөн эсвэл байхгүй, Грам эерэг болон сөрөг эмгэг төрөгч нян, Мобилункусууд (грам эерэг болон сөрөг морины тах мэт тахир дугуй хэлбэртэй нарийн савханцар)-ийг микроскопоор харж үнэлсэн. Үүн дээр суурьлан Ньюжентийн шалгуур нь 0–10 оноогоор үнэлсэн ба Ньюжентийн шалгуур 0–3 оноо хэвийн 4-6 оноо бол дунд буюу наалдацын шинжилгээг давтан өгөх шаардлагатай 7 – 10 оноогоор үнэлэгдсэн бол нянгийн вагиноз болон үтрээний үрэвсэлтэй гэж тодорхойлсон. Бид энэхүү судлагааг хийж гүйцэтгэхдээ ёс зүйн зөвшөөрлийг АШУҮИС Судалгааны Ёс Зүйн Хорооны 2021/12/20ны Д/02 тоот тушаалаар зөвшөөрөл авч, судалгааны үр дүнгийн тоон үзүүлэлтийн боловсруулалт хийхдээ stata16 программ ашиглан хийж гүйцэтгэлээ.

Үр дүн: Судалгаанд хамрагдасын 90% нь өвөрмөц үүсгэгчид илэрсэн бөгөөд эдгээрийн 68.9% (62) нь Гарднеррелла вагиналис, 43.3% (39) нь Уреаплазм парвум, 36.6% (33) нь Микоплазм хоминис, 32.2% (29) нь Кандида албинкас тус тус эзэлж байгаа нь бэлгийн замаар дамжих халдвар нь умайн хүзүүний үрэвсэл үүсгэх шалтгаан болж байна. Судалгаанд нийт хамрагдасадын 92.2% (83) үтрээний хэвийн бус ялгадастай тодорхойлогдлоо. Мөн үтрээний наацын шинжилгээгээр тодорхойлоход 43,2%(35) ньюжент шалгууpаар 0-3 оноотой, 4-6оноотой 51,8%(42), 7-10 оноотой 4,9%(4) байгаа нь умайн хүзүүний үрэвсэл нь үтрээний үрэвсэлээс хамаарал бага байгааг харуулж байна.(хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын үтрээний наацын шинжилгээний үр дүн

Ньюжентийн оноо	0-3 оноо хэвийн	4-6 оноо эрсдэлтэй	7-10 оноо Бактерийн шалтгаант үтрээний үрэвсэл
Оролцогчид (N=100)	35	42	4
Хувь (%)	43.2	51.8	4.9

Судалгаанд оролцогчидоос 86,4%(70) нь хавсарсан бэлгийн замын хавсарсан халдвартай болох нь тодорхойлогдсон бол давтан шинжилэхэд n=30 хийхэд Микоплазм гениталиумаар үүсгэгдсэн 50%, Хламид болон Трихомониаз үүсгэгдсэн тохиолдолдуудын 100% эдгэрсэн тодорхойлогдлоо.

Хэлцэмж: Бид өөрсдийн судалгааний үр дүнг бусад судлагааны үр дүнтэй харьцууллаа.[1-2] Мөн судлаач Taylor S. нарын 2013 оны жирэмсэн бус эмэгтэйчүүдэд n=100 хийсэн судалгааны умайн хүзүүний өвөрмөц үүсгэгчидийн судалгаагаар Мөөгөнцрийн халдвар 3%, Нейссерийн гонококкын халдвар 5% гэсэн бол бидний судалгаанд мөөгөнцрийн халдвар 32% ба нейссерийн гонококк 8,8% гэж тодорхойлсон бидний хийсэн судалгааны эдгээр судлаачдын үр дүнгээс их байлаа.[6] Түүнчлэн Гарднеррелла вагиналис 68.9% (62), Уреаплазм парвум 43.3% (39), Микоплазм хоминис 36.6% (33), Кандида албинкас 32.2% (29), Цитомегаловирус 20% (18), Цреаплазм уреалитикум 17.7% (16) байгаа нь зонхилон үүсгэгчдыг судалсан цөөнгүй судалгаатай харьцуулахад тус тус өндөр болох нь тодорхойлогдлоо. Судалгаанд хамрагдагсад хавсарсан халдвар их байгаа нь зонхилон тохиолдох үүсгэгчийн тоо болон хувийг ихэсгэж байна. Судалгаанд хамрагдагсадын 86.4% (70) хавсарсан халдвартай. Түүнчлэн давтан шинжилгээг үзэхэд Микоплазм хоминис 50%, Хламид ба Трихомониаз 100% эдгэрсэн байсан нь 2013онд Anagrius болон бусад судлаачдын хийсэн “Умайн хүзүүний үрэвсэлтэй эмэгтэйчүүдийн эмчилгээ болон удирдамж” судалгаанд 62 эмэгтэйг хамруулан 1г азитромицин 1 удаа уулгахад 50 (96%) эмчилгээний үр дүнтэй байгаа нь дүйж байна.

Дүгнэлт: Полимераза гинжин урвалын оношлууpаар өвөрмөц үүсгэгчидыг тодорхойлон умайн хүзүүний үрэвсэлтэй эмэгтэйчүүдэд үтрээний наацын шинжилгээгээр Лактобацилл, Грам эерэг болон сөрөг эмгэг төрөгч нян, Мобилункусуудыг микроскопоор харж үнэлэхэд (Ньюжентийн шалгуур) нянгийн гаралтай үртээний үрэвсэл буюу 7-10 оноотой 4,9%(4) тодорхойлгдсон нь умайн хүзүүний үрэвсэл үүсч байгаа хамаарал сул байна.

Ном зүй:

1. *Taylor, S.N., et al., Prevalence and treatment outcome of cervicitis of unknown etiology. Sex Transm Dis, 2013. 40(5): p. 379-85.*
2. *Workowski, K.A. and G.A. Bolan, Sexually transmitted diseases treatment guidelines, 2015. MMWR Recomm Rep, 2015. 64(Rr-03): p. 1-137.*
3. *Young, C. and C. Argáez, CADTH Rapid Response Reports, in Management and Treatment of Cervicitis: A Review of Clinical Effectiveness and Guidelines. 2017, Canadian Agency for Drugs and Technologies in Health Copyright © 2017 Canadian Agency for Drugs and Technologies in Health.: Ottawa (ON).*
4. *Lusk, M.J., et al., Cervicitis etiology and case definition: a study in Australian women attending sexually transmitted infection clinics. Sex Transm Infect, 2016. 92(3): p. 175-81.*
5. *Martin, I., et al., Decline in Decreased Cephalosporin Susceptibility and Increase in Azithromycin Resistance in Neisseria gonorrhoeae, Canada. Emerg Infect Dis, 2016. 22(1): p. 65-7.*
6. *Meena, V. and C.L. Bansal Study to Evaluate Targeted Management and Syndromic Management in Women Presenting with Abnormal Vaginal Discharge. J Obstet Gynaecol India, 2016. 66(Suppl 1): p. 534-40.*
7. *Paavonen, J., et al., Randomized treatment of mucopurulent cervicitis with doxycycline or amoxicillin. Am J Obstet Gynecol, 1989. 161(1): p. 128-35.*
8. *Sethi, S., et al., Mycoplasma genitalium: an emerging sexually transmitted pathogen. Indian J Med Res, 2012. 136(6): p. 942-55.*

Results of vaginal smear analysis of women with cervicitis

Yesun-Erdene G[1], Baatarkhuu O[2], Bolorchimeg B[1]

[1]Department of Gynecology and Obstetrics, School of Medicine, MNUMS
[2]Department of Infectious Disease, School of Medicine, MNUMS
E-mail: yesuunuu0608@gmail.com, Tel: +976-88859694

Background: Cervicitis is a clinical syndrome characterized by purulent or muco-purulent discharge visible from the intracervical canal or by cervical smear examination.[1-3] Acute cervicitis may be caused by trauma or rupture of the cervix during childbirth or abortion. but usually causes sexually transmitted diseases, especially Neisseria gonococci, Chlamydia, and Herpes simplex virus.[2] Cervical ulcers are caused by the redness and inflammation of the cervix, and the ulcers are a precursor to cancer.[4] According to the Unified Statistics Database of Mongolia, 50.8% (1677293) of the total population of the country in 2019 are 3296866 people, of which 51.6% (865781) are women of reproductive age (15-49 years). According to a study conducted by the World International Organization, about 70% of women visiting women's hospitals have inflammatory diseases of the lower pelvic organs, and most of them are pelvic inflammatory disease and cervicitis. Also, our country lacks statistical data on the classification of women's inflammatory diseases by studying their data and developing treatment results.

Aim: To identify the causative agents of women with non-pregnant cervicitis and to monitor the results by coordinating laboratory tests.

Results: We compared the results of our research with the results of other studies.[1-2] Also, according to the study of unique pathogens of the cervix conducted by researcher Taylor S. in 2013 on n=100 non-pregnant women, fungal infection was 3% and Neisseria gonococcal infection was 5%. In the study, fungal infection was 32% and Neisseria gonococci were 8.8%, which was higher than the results of these researchers. Candida albincas 32.2% (29), Cytomegalovirus 20% (18), and Creaplasma urealyticum 17.7% (16) were found to be higher than in many studies that investigated the dominant pathogens. The high number of co-infections in the study subjects increased the number and percentage of prevalent pathogens. 86.4% (70) of the respondents had co-infections. In addition, after repeated tests, 50% of Mycoplasma hominis, 100% of Chlamydia and Trichomoniasis were cured, which is the result of the 2013 Anagrius and other researchers' "Treatment and Guidelines for Women with Cervicitis" study involving 62 women who administered 1g of azithromycin 1 time is waiting.

Conclusion: In women with cervicitis, specific pathogens were determined by polymerase chain reaction, and vaginal smear analysis of Lactobacillus, Gram-positive and negative pathogenic bacteria, and Mobilunkus microscopically evaluated (Nugent's criteria) bacterial vaginosis or 4.9% (4) with 7-10 points. It is determined that there is a weak correlation with the development of cervicitis.

Keywords: Sexually Transmitted Infections, Cervix, Nugent Score, Polymerase Chain Reaction, Vaginitis